

**Профессор Ё.Довчин**  
МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш

### **Харьцуулсан улстөр: хөгжил, хандлага**

**Өгүүллийн товч утга:** Харьцуулсан улстөр бол улстөрийн шинжлэх ухааны эрчимтэй хөгжиж буй салбар мөн. Ийм учраас гадаад орнуудад төдийгүй манайд ч сүүлийн үед энэ салбарт улам бүр анхаарах болж байна. Эл салбар судлах зүйлээрээ бус харин аргаараа нэрлэгдсэн гэдэг. Харьцуулсан улстөр улстөрийн шинжлэх ухааны бие даасан салбар болохын хувьд бусад дэд салбаруудаас агуулга, арга хоёрын нэгдлээрээ ялгарч байдаг. Харьцууллын аргыг улстөрийг судлахад хэрэглэсэн нь онолыг шалгах, онолыг бүтээх, шинэ мэдлэг бий болгох бололцоог өргөжүүлж өгсөн. Гагцхүү харьцуулснаар бид өөрийн улстөрийн системээ бүрэн ойлгож, төсөөллөө улам гүнзгийрүүлэх болно. Энэ бол бидний танин мэдэхүйн зайлшгүй шаардлага, түүнийг зохион байгуулах арга мөн. Тиймээс ч Токвиль: "Харьцуулах зүйлгүй бол оюун ухаан хаашаа явахаа үл мэднэ" хэмээжээ. Иймд харьцууллын арга байгалийн шинжлэх ухаанд түгээмэл хэргэлэгддэг туршилтын аргыг нийгмийн ухаанд орлодгоороо онцлог бөгөөд харьцуулал улстөрийг шинжлэх ухааны үндэслэлтэй судлахын арга зүйн цөм болдог байна. Энэ өгүүлэлд харьцуулсан улстөрийн аргазүйн хөгжлийн онцлог, асуудлууд, цаашдын чиг хандлагын талаар авч үзсэн болно.

**Түлхүүр үг:** Харьцуулал, "бихевориаль" хувьсгал, бүтэц чиг үүргийн хандлага, харьцууллын цар хүрээ, хийсвэрлэлийн төвшин.

Харьцуулсан улстөр олон жилийн түүхтэй. Орчин үеийн улстөрийн шинжлэх ухаан бий болохоос бүр өмнө улстөрийн сургаалийн түүхэнд харьцууллын аргыг хэрэглэж байсан жишээг Аристотелоос эхлээд цөөнгүйг нэрлэж болно. Гэхдээ XIX зууны хоёрдугаар хагас харьцуулсан улстөрийн хөгжлийн онцгой үе байв. Энэ үед улстөрийн шинжлэх ухаан хөл дээрээ бат зогсож, дотоод бүтцийн хувьд нарийсаж ирэхэд харьцуулал нь судалгааны ерөнхий арга төдий бус, харин улстөрийн мэдлэгийн онцлог хүрээ болж хувирч эхэлсэн аж. Ер нь улстөрийн шинжлэх ухааны өсөлт хөгжил харьцуулсан судалгааны нөлөө дор явж ирсэн бол харьцуулсан улстөр тусгаар чиглэл болон өсч өндийх явцдаа эргээд улстөрийн шинжлэх ухаанд гарсан арга зүйн өөрчлөлтүүдийг тусгаж авч байсан нь тодорхой байдаг. Дурдсан үед боловсруулж хэрэглэж байсан арга зүйн үндсүүд бараг XX зууны 40-өөд оны дунд хүртэл харьцуулсан судалгаанд гол нөлөөтэй байжээ. Энэ үеийн "уламжлалт" гэж нэрлэгдсэн арга хандлагын мөн чанар улстөрийг гол төлөв институциональ хүрээгээр хязгаарлаж, түүнийг хууль зүй, хэлбэр талаас өнгөц тоочин бичихэд оршиж байсан гэж болно.

Гэвч улстөрийн шинжлэх ухаанд шинэ уур амьсгал улам бүр лавширч, XX зууны 50-60-аад онд харьцуулсан улстөр АНУ, бусад орнуудад эрч хүчтэй хөгжсөн түүхтэй. Юуны өмнө судалгааны ойлголт, таамаглалуудыг дүн шинжилгээний үндсэн дээр томьёолох замаар улстөрийн үзэгдэл, үйл явцын адил төсөөтэй шинжүүдийг нээж олох, тэдгээрийн үнэн зөвийг эмпирик аргаар шалгахад харьцууллын аргын давуутайг тэмдэглэх болсон. Улстөрийн шинжлэх ухаанд нэвтэрсэн бихевиораль хийгээд бүтэц чиг үүргийн (Structural-functional) хандлагууд арга зүйн онцгой нөлөө үзүүлснээр, нэг талаас аль ч төр улсын улстөрийн системийн бүтэц, чиг үүргийг харьцуулж болох, нөгөө талаас улстөрийн үйл байдалд гарч байгаа илэрхий өөрчлөлтүүдэд тулгуурлан, дэвшүүлсэн таамагуудаа эмпирик үүднээс нотлох үндсэн дээр улстөр, улстөрийн үйл явцын тухай объектив мэдлэг бий болгож болно гэсэн санааг харьцуулсан судлаачдад төрүүлсэн байна. Үүний үр дүнд мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх арга техник нарийсч, норматив чиглэлийн онолоос эмпирик чиглэлийн онол тийш эргэж, өөрөөр хэлбэл, харьцуулсан улстөрд онолыг баримжаалах, өндөр төвшинд нэгтгэн дүгнэх бололцоо бий болж иржээ.



Иймээс 50-60-аад онуудын сүүл үеийн харьцуулсан улстөрийг "шинэ" гэж нэрлэдэг нь үүнтэй холбоотой буйзаа. Энэ үед америкийн эрдэмтэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн нь илт бөгөөд Парсонс Мертон, ялангуяа Г.Алмонд, Д.Истон нар бүтэц чиг үүргийн аргыг улстөрийн системүүдийг харьцуулахад тохируулж боловсруулсан нь их нөлөө үзүүлжээ.

Эл үеийн шинэ хандлагын гол онцлог нь "өргөн цар хүрээтэй харьцуулал" байв. Алмонд,бусад судлаачид урьд нь голдуу хөгжингүй ертөнц,тухайлбал, Өрнөд Европ, АНУ-д анхаарлаа төвлөрүүлж,мөн үүндээ тохирсон үзэл баримтлалд баригдаж байсныг "эвдэж", хэв шинжээс нь үл хамааран аль ч улстөрийн системийг харьцуулах боломж олгох нийтлэг онол,арга зүйг хөгжүүлэхийг зорьсон байна. Чингэж судалгаа газар нутгийн хувьд тэлсэн нь улстөрийг ч бас явцуу хүрээнээс гаргах, тухайлбал, улстөрийг институт талаас хууль зүйн хэм хэмжээ, зарчмуудтай холбон үздэг дээр өгүүлсэн уламжлалт хандлагаас хөндийрч, улстөр гэдэг нь бодит байдал, амьдрал дээр чухам ямар байх вэ гэдгийг тандан судлах нь "шинэ" харьцуулсан судлаачдын тэргүүн зорилт болсон ажээ. Иймд төр засгийн албан ёсны институтүүдийн оронд улстөрийн дэд бүтэц-улстөрийн намууд, сонирхлын бүлгүүд,олон нийтийн санаа бодол зэрэгт судалгааны ажил төвлөрөх хэрэгтэй болсон. Ийнхүү өрнөдийн хууль ёсны институтүүдийг судалдаг хүрээнээс хальж гарсан нь өрнийн биш дэглэмүүдийг нарийвчлан судлахад хүргэж, улмаар үүнээс үүдэн харьцуулсан улстөрийн "дэлхийн амбиц" төрсөн бололтой. Аль болохоор олон улс орнуудыг хамруулан судалгаа хийх энэхүү эрмэлзэл улстөр судлалын хамрах цар хүрээг өргөжүүлээд зогсоогүй дэлхийн хэмжээний эмпирик харьцуулсан судалгаа явуулахад онол баримтлалын аппаратыг бий болгохыг шаардсан нь лав. Энэ дунд шинэ хандлагууд, тэдгээрийн дотроос бидний дурдсан бүтэц чиг үүргийн хандлага боловсронгуй болж тодорч гарч ирсэн байна.

Урьд нь харьцуулсан улстөр улстөр,эдийн засгийн хувьд тэгширсэн, төр, иргэний нийгэм нь хоорондоо илт зааглагдсан, төрийн институтүүд нь систем дотроо дор бүртээ тусгай үүрэг гүйцэтгэдэг болсон барууны ардчилсан системүүдийг хамарч байсан бол одоо өрнийн бус төдийгүй, төр, иргэний нийгэм нь зааг ялгаагүй, дагнасан үүрэгтэй тусгай улстөрийн институтүүд байхгүй "болхи" гэхээр улстөрийн системүүдийг судлах болсон. Учир иймд төр засгийн албан ёсны институтүүд, хэрэг дээрээ төр хэмээх ойлголтыг хойш тавьж, түүний оронд илүү хийсвэр ойлголт болох "улстөрийн систем"-д шилжих хэрэгтэй болсон ажээ. Уул шинэ нэр томъёо нь хууль ёсны, хууль ёсны бус олон төрлийн институтүүдийг анхааралдаа авах боломж судлаачдад өгсөн нь барууны бус улстөрийг ойлгоход нэн чухал байсныг Алмонд тэмдэглэсэн байдаг.<sup>1</sup>

Гэвч 80-аад оны харьцуулсан улстөр судлалын шинэ үе институциональ судалгаанд эргэн орох шаардлагатайг цохон тэмдэглэж, эн түрүүнд "төр"-ийн (State) судлалыг сэргээх ёстой гэж үзэх болжээ. Өмнөх судлаачид үндсэндээ улстөрийн шинжлэх ухааны судлах зүйл нь үйл ажиллагаа, үйл байдал, шууд хэлбэл, чиг үүрэг гэж үзэж түүхэн тодорхой институтүүдийг зах ирмэг рүү шахаж байсан гэж нотлох болсон.Институтүүд бол гол "тоглогч" мөн учир хувь хүний үйл байдалд, бас үйл явцын эцсийн үр дүнд тодорхойлогч нөлөөтэй гэж үзсэн.Чингэж институтүүд улстөрийн системүүдийн харьцууллын үндэс суурь, улстөр бол үйл явц шинжтэй гэж зөвшөөрсний үр дүн болох ёстой ажээ. Гэвч институтийн хандлага нь бихевиораль, эсвэл бүтэц чиг үүргийн тодорхойлолтуудаас чанарын ялгаа байхгүй гэж судлаачид үзэх нь байдаг аж.<sup>2</sup> Үнэхээр ч парадигмын хувьд төдийлөн ялгаа байхгүй нь зарим таар ажиглагддаг.

Харин асуудлын гол нь харьцуулалтын хамрах цар хүрээнд байгаа бөгөөд "шинэ" харьцуулсан улстөр судлаачид дэлхийн хэмжээний харьцуулалд зориулж үзэл баримтлалаа хөгжүүлсэн бол арай хойч үеийнхэн харьцууллын



хамрах хүрээг хумиж, бүс нутгаар, тэр ч атугай тухайн нэг орноор<sup>3</sup>, ер нь л маш цөөн тооны улсаар (Small N) хязгаарлахыг чухалчилсан байна.

Дүгнэвээс, Алмонд, түүний багийнхан бүх тохиолдолд таарч тохирох үзэл баримтлалыг боловсруулж хийсвэрлэлийн өндөр төвшинд ажилласан бол сүүлийн үеийн сургуулийнхан хийсвэрлэлийн дунд, бүр доод төвшинд өрсөлдөж, тэдний хувьд тодорхой утгын(context)өвөрмөц онцлог л шийдвэрлэх хүчин зүйл болдог ажээ. Өөрөөр хэлбэл, энэ нь парадигмын шилжилт биш, харин харьцууллын цар хүрээний шилжилтээс үүдсэн хийсвэрлэлийн төвшингийн шилжилт ажээ.<sup>4</sup>

Иймд 50-60-аад оны сүүлчээр харьцуулсан улстөрд гарсан шинэчлэл онолын төвшинд гэхээсээ илүү аргын төвшинд тусгалаа олсон гэдэг нь үнэний хувьтай бөлгөө. Харьцууллын цар хэмжээ хамжааргатай болж, нэг бүс нутаг, эсвэл цөөн тооны орноор хязгаарлагдсанаар үзэл баримтлал нарийсан боловсрогдох бололцоо нэмэгдсэн байна. Нэг үгээр, институтүүд ба төр харьцууллын төвлөрөх цэг байх ёстойг "дахин нээсэн" нь тэдгээр нь дор бүрнээ чухал байсан төдийгүй, хийсвэрлэлийн доод төвшин, харьцууллын цар хүрээний хумигдалт ийм байдалд хүргэсэн хэмээдэг. Учир нь хийсвэрлэлийн өндөр төвшин, мөн дэлхийн хэмжээний харьцууллын нөхцөлд бүтэц, үүрэг, роль гэх мэтийн илүү хийсвэр ойлголтуудад институтийн өвөрмөц онцлог "уусч" алга болж байсан гэсэн үг болж байна.

Харьцууллын цар хүрээ нарийсч байгааг зарим судлаачид (1) одоо дэлхийн байтугай бүс нутгийн "амбиц"-тай харьцуулал байхгүй болсон, (2) харьцууллыг зөвхөн тухайлсан бүс нутгийн хүрээнд гол төлөв хийх болсноос бүс нутгаар дагнан мэргэшиж, бүр өөрийн гэсэн эрдэмтэдтэй, бие даасан сэтгүүл хэвлэлтэй болж ирсэн, (3) арга зүйн мэтгэлцээний дүнд цөөн тооны орнуудын харьцуулалд (Small N comparison) илүү тал өгөх хандлагатай болсон зэргээр тайлбарлаж байгааг анзаарч болно.<sup>5</sup> Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд анхдагч, хоёрдогч, гуравдагч ертөнцийн системүүдийн онол өнөө үед хэдийгээр маргаантай болсон ч уг хандлагыг харьцуулалд ашиглахаас эрдэмтэд ор тас татгалзаагүй байгаа бололтой.<sup>6</sup>

Орчин үед энэ талд хоёр хандлага байгаа бололтой. Нэг талаас "шинэ" гэгдэж байсан харьцуулсан улстөр судлаачдыг бодвол харьцууллыг бүс нутгаар хязгаарлах замаар тэдгээр орнуудын талаар нэгдсэн дүгнэлтүүд гаргаж, ерөнхий загваруудыг хэрэглэхийг эрмэлздэг, нөгөө талаас, хэдхэн тооны орнуудыг шууд, гүнзгий орж шинжлэх нь тухайн орнуудын нийтлэг дүр зургыг гаргаж ирэх сайн талтай гэж үздэг байна. Эдгээрийн давуутай тал нь хэдийгээр цөөн тохиолдол (case) байлаа ч тоон шинжилгээ хийж буурьтай дүгнэлтүүд хийх, мөн тухайн тохиолдолд гүнзгийрүүлсэн чанарын шинжилгээ хийж ул суурьтай үр дүнд хүрэх боломжтой ажээ.

Ийнхүү институциональ хандлагын хувьд гурван өөр ертөнцийг харьцуулахдаа институтүүдэд гол анхаарлаа төвлөрүүлээгүй нөхцөлд жишээ нь, эдийн засгийн хөгжлийн төвшин, улстөрийн соёлын ялгааг заавал авч үзэх хэрэгтэй болдог байна. Харин харьцуулал харьцангуй адил төсөөтэй тохиолдлууд (cases), жишээлбэл, аж үйлдвэржсэн ардчиллын орнуудаар хязгаарлагдана гэвэл эдийн засгийн хөгжлийн төвшин, улстөрийн соёлын хэв загвар, нийгмийн бүтэц зэргээрээ ойролцоо учир судлаач анхаарлаа харилцан адилгүй улстөрийн бүтэц, үйл явцад чиглүүлэх хэрэгтэй болно. Улстөрийг тодорхойлогч хүчин зүйлс-эдийн засаг, соёл, нийгэм зэрэг нь энэ тохиолдолд ялгавар багатай учир харин хоорондоо ялгаатай улстөрийн бүтэц, үйл явцууд үйл явдлын учир шалтгааныг тайлах түлхүүр болох ажээ. Эцсийн бүлэгт энэ нь улстөр аливаа ялгааг бий болгодог гэдгийг чухам юу улстөрийг олон янз болгодог вэ гэдгийн дээгүүр авч үзэхэд хүргэдэг байна. Жишээ нь, ардчилал нийгэм-эдийн засгийн төвшингөөс биш, харин улстөрийн сонголтуудаас илүү хамааралтай байх болно гэсэн үг. Эндээс үзвэл "Small N" харьцуулал нь



харьцууллын хүрээг багасгаснаараа тухайн орнуудын хоорондоо харьцуулагдах чанарыг дээшлүүлэхийн зэрэгцээ харьцуулах үзүүлэлтүүдийн тоог цөөлж өгч байгаагаараа ач холбогдолтой гэж болохоор байна.

Харьцуулсан улстөрд судалгааны үндсэн нэгж гол төлөв үндэсний улстөрийн систем, төр, улс орон байсаар ирсэн ч энэ асуудал өнөөдөр ч нэг мөр шийдэгдээгүй гэж болно. Эдийн засаг, улстөрийн даяаршал, улс гүрнүүдийн харилцан хамаарал улам бүр хүчтэй болж байгаа одоогийн нөхцөлд олон улсын хүрээлэл үндсэн нөхцөл нь болдог учраас тухайн нэг орон харьцуулсан шинжилгээний бие даасан нэгж байж чадахгүй, нөгөө талаар тухайн орон түүхэн хөгжлийнхөө цаг хугацааны үе бүхэнд өөр өөр байдгийг бас харгалзах ёстой гэж үзэж буй. Уг асуудлыг шийдвэрлэхийн тулд тухайн орныг дан ганц хуваагдашгүй тохиолдол гэдгээс татгалзаж, харин тодорхой үзүүлэлтүүдийг нэгж болгон авч(жишээ нь, сонгуулийн систем гэх мэт) харьцуулах саналыг эрдэмтэд дэвшүүлдэг байна.<sup>7</sup> Мөн "holist" гэж нэрлэгддэг хандлагыг хэрэглэхийг бас санал болгодог агаад энэ ёсоор шинжилгээний нэгжүүд нь харилцан хамаарал бүхий бүхэллэг байх ба иймээс тэдгээрийн хооронд шалтгаалцлын харилцаа байдаг гэдгийг иш үндэс болгодог аж. Мөн дэлхийн системийн онолоор улс орнуудын дотоод хөгжилд дэлхийн системийн нөлөөллийг авч үзэж энэ тохиолдолд тухайн орны эдийн засаг, улстөрийн систем гадаад хүчин зүйлд нээлттэй байдаг тул заавал хамааралтай байх ёстой гэж нотолдог байна. Түүнчлэн гадаад үзүүлэлтүүдэд хяналт тавих замаар харьцуулсан судалгааг хоёр аргаар, тухайлбал, хамгийн адил төсөөтэй системүүдийн харьцуулал, эсвэл хамгийн өөр өөр системүүдийн харьцуулал хийж тухайн орон, түүнийг тойрсон хүрээллийн харилцан шүтэлцээг шийдвэрлэх оролдлого бас хийжээ.

Харьцуулсан улстөрд судлаачдын дунд санал зөрөлдөөн үүсгэдэг бас нэг асуудал бол уул үндэстний туршлагыг олон улсын "хэмжүүр" дээр тавихад хэрэглэгдэх олон янзын үзүүлэлт, индекс, индикаторын тухай юм. Нэг үгээр, хийсвэр ойлголтуудаар илэрхийлэгдсэн шинж чанарыг тодорхой үзүүлэлтүүд дээр буулгана гэсэн үг. Нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүдийг олон улсын байгууллагуудын мэдээллийг ашиглаад гаргахад харьцангуй хялбар байдаг бол харин институтүүдийг хэмжих, харьцуулахад ийм бэлэн зэлэн мэдээлэл тэр бүр гар дор байдаггүй нь ойлгомжтой.

Иймд үзүүлэлт, индексүүдийг боловсруулах, сонгон авах нь судлаачын байр суурь, туршлага, мөн эмпирик мэдээллээ цуглуулж боловсруулсан арга, харьцууллын сонгож авсан хэв маяг зэргээр тодорхойлогддог байна. Индекс нь хоорондоо харилцан хамаарал бүхий хэд хэдэн индикаторыг нэгэн шинэ нэгдсэн индикатор болгохыг голдуу хэлнэ. Хэдийгээр үр дүнг нь янз бүрээр тайлбарлах явдал байгаа ч хэрэглэгдэж буй эмпирик индикаторуудыг судлаачид дүгнэж үзээд энэ салбарт ашиглаж буй арга зүй улам ойртсон, мөн тэдгээрийн үндэслэгээ, үнэн зөв талаас ч дэвшил гарсан гэж үздэг ажээ. Харьцуулсан улстөрд, ялангуяа ардчиллын төвшинг тогтоох, энэ чиглэлээр улс орнуудыг ангилах, зэрэглэхэд хуримтлагдсан эмпирик материал дээр түшиглэн индикатор, индексүүдийг хэрэглэх талаар багагүй туршлага бий болжээ. Тухайлбал, Катрайтын улстөрийн хөгжлийн индекс, Нейбаурын ардчилсан үйл ажиллагааны индекс, Ванханены ардчиллах үйл явцын индекс, "Freedom House"-ын эрх чөлөөний индекс, Боллены улстөрийн ардчиллын индекс г.м.нэрлэж болно.<sup>8</sup> Эдгээр ардчиллын индексүүд ихэвчлэн ардчиллын либерал ойлголтод суурилдаг нь судлаачдын үзэл бодолтой холбоотой төдийгүй либерал загвар, түүний шинж чанарыг тоон үзүүлэлтээр харуулахад агуулга талаасаа нэлээд дөхөмтэй байдаг орших ажээ.

Харьцуулсан улстөрийн судалгааны нэгжээс гадна судлах сэдвүүд нь ч өөрчлөгдөж, дээр дурдснаар төр засгийн институтуудээс улстөрийн дэд бүтэц рүү шилжсэн нь улам өргөжиж, шилжилтийн үйл явц, улстөрийн орчин хүрээлэл, сонирхлын бүлгүүд ба шинэ корпоративизм, олон нийтийн шинэ хөдөлгөөнүүд,



постматериал үнэт зүйлс, үндэстэн угсаатан, хэл, нас хүйсийн хүчин зүйлсийг судалдаг болжээ. Мэдээж харьцуулсан улстөр үүссэн цагаасаа институтүүдийг судалж ирсэн гэж болох ч өнөөгийн шатанд тэдгээрийн роль, үр дүнд илүүтэй анхаарч байгаагийн зэрэгцээ улстөрийн бодлого хэрхэн бий болж, түүнд хуучин, шинэ институт, хүчин зүйлс яаж нөлөөлж байгааг онцгойлон үзэх болсныг (Comparative Public Policy) үгүйсгэх аргагүй. Үүнтэй уялдуулан тэмдэглэхэд аль аль хандлагын ач холбогдлыг хэтрүүлэн үнэлэх, тухайлбал, нийгэм-эдийн засгийн хүчин зүйлс, улстөрийн систем хоёрын хооронд ямарч холбоо байхгүй гэх зэрэг нь өрөөсгөл байр суурьт хүргэж болох бөгөөд энэ тал дээр гагцхүү тэнцвэрийг олох нь чухлыг зарим эрдэмтэд<sup>9</sup> заасан байдгийг анхаарах нь чухал юм.

Харьцуулсан улстөрийн арга зүйн өөрчлөлтийг тухайлбал, харьцууллын цар хэмжээний өөрчлөлттэй холбон цухас өгүүлсэн.

Гэвч үүний хамт бихевиораль, бүтэц чиг үүргийн хандлагуудыг шүүмжлэлтэй авч үзэх болсноос үүдэн харьцуулсан улстөрийн арга зүйг зарим хандлагууд<sup>10</sup> тодорхойлох чигтэй байгаа нь анхаарал татдаг. Жишээ нь, *радикал* хандлага постмодерн болон феминист улстөр-онолын чиг баримжаагаар илэрдэг байна. Эдгээр нь улстөрийн орчин үеийн шинжлэх ухааны ойлголтыг өөр өөрийн байр сууринаас шүүмжилдэг ч "рациональ-шинжлэх ухааны" эсвэл "булчингийн хүч давамгайлсан" ганц хэв маяг улстөрийн танин мэдэхүйд ноёрхож байгааг эрс өөрчлөх хэрэгтэй гэдгээрээ агаар нэг ажээ.

Түүнчлэн түүхэн харьцууллын арга зүйг сэргээх нь зүйтэй гэж байна. Энэ нь ялангуяа К.Маркс, М.Вебер нарыг эдүгээчлэн судлах эрмэлзэлд тусгалаа олжээ. Хоёр эрдэмтэн нийгмийн зүй тогтлын асуудлаар эсрэг тэсрэг байр суурьтай хэдий ч тэдний арга зүйн уламжлал нь нэг талаас харьцууллын эмпирик-тоон аргын явцуурлыг эсэргүүцэх, нөгөө талаас судалгаанд социаль хийгээд нийгэм-соёлын хүчин зүйлсийн тайлбарлах үүргийг дээшлүүлэх боломж олгодог байна.<sup>11</sup>

Статистик шинжилгээний арга хэрэгслийг хөгжүүлж ашиглах, мөн *тооны* болон *чанарын* судалгааны нэгдлийг хангах шинэ хандлагуудыг хэрэглэх замаар харьцуулсан шинжилгээний арга зүйг өргөтгөх чиглэл бас байна. Үүнд онол, тухайлбал, түүний үүрэг нь таамаглал дэвшүүлэн тавих, эмпирик мэдээллийг харьцуулах, тайлбарлахад өсч байна. Онол харьцууллын арга хэрэгсэл бус, харин харьцуулсан шинжилгээний зорилго байж болдог аж.

Макро төвшингийн харьцуулал ээдрээ зөрчлийг хэт хялбарчилж, судалгаа нь бодит байдлыг зөв тусгасан онолоор гачигдаж байна, мөн улстөрийн социологи дахь түүхэн харьцууллыг ерөнхий онолгүй гэж шүүмжлэх болсон нь эмпирик шинжилгээг шалтгаалцлын харилцааг нэгтгэн дүгнэхтэй хослуулсан онолын шинэ загваруудыг бий болгоход хүргэжээ. Энд эдийн засгийн сургаалиудаас эх авсан *рациональ сонголтын* болон *тоглоомын* онолын загварууд, мөн *шинэ институциональ* үзэл баримтлалыг оруулдаг байна. Харьцуулсан улстөрийн өнөөгийн хийгээд хэтийн хандлага энэ бүхнээр дуусахгүй нь лавтай. Судлах сэдэв, арга зүйн хувьд уг салбарт нэг ёсны өөрчлөн байгуулалт болж байгаагийн дотроос гуравдагч давалгаатай холбогдон *ардчиллах үйл явцыг* судлах, харьцууллын арга зүйг нь боловсруулах асуудал гол байранд тавигдах болсныг тэмдэглэх нь чухал.

Харьцуулсан улстөрд ерөнхий загвараас *тухайн орныг тусгайлан* судлахыг голчлох хандлага ажиглагдаж байгаа нь үндэсний онцлогийг тэргүүн зэрэгт тавих, түүний дотор тоогоор илэрхийлэх аргагүй соёлын "уламжлалуудыг" нь нарийн судлахад гойд анхаарч байгаа хэрэг. Энэ нь тухайн тохиолдлууд, улс орнуудыг гүнзгий ойлгоход хүчээ төвлөрүүлнэ гэсэн үг юм. Тэгэхлээр бүр задаргаа хийж, *соёлыг тусгайлан* судлах (ж-нь, Англиар ярьдаг үндэстнүүд), *үндэстнийг тусгайлан* судлах (ж-нь, Нэгдсэн Вант Улс), *институтийг тусгайлан* судлах (ж-нь, Тэтчерийн засгийн газрын үеийн



Нэгдсэн Вант Улс) гэж байж болох нь.<sup>12</sup> Харьцуулсан улстөрийн өнөөгийн өөрчлөлт улстөрийн шинжлэх ухааны хөгжлийн шинэ шатанд болж байгаагаараа онцлог гэж болно. Уул шинжлэх ухаан улам бүр дэлхийчлэгдэж, улам бүр мэргэшсэн шинжтэй болж байна. Шинжлэх ухааны нэр томъёо, ойлголт-категорийн аппарат, онол-арга зүй нийтлэгдүү болж, өөрөөр хэлбэл дэлхийн өнцөг булан бүрт судлаачид нэг хэлээр ярих болсон гэсэн үг. Улс орон, бүс нутаг бүрт мэргэжлийн хүмүүс ажиллаж, эрдэмтэд судлаачдын олон улсын сүлжээ улам хүрээгээ тэлж байгаа ажээ. Энэ нь судалгаанд мөнгө хөрөнгө зарцуулах, үндэсний мэргэжилтнүүд хамтран ажиллах, мэдээлэл солилцох, хуримтлагдсан эмпирик материалыг ашиглаж харьцуулал хийх бололцоог нэмэгдүүлж байна. Үүний зэрэгцээ *гүнзгийрүүлсэн* судалгаа, *ерөнхийлөн нэгтгэн дүгнэсэн* хандлага хоёрыг гагцхүү хослуулах замаар өвөрмөц нарийн ширийнийг тусгасан харьцуулсан судалгааг бий болгож болно гэсэн санал зөв зүйтэй мэт. Улстөрийн шинжлэх ухаан мэргэшихийн хэрээр "Case study" судалгаа ерөнхий онол, загварт дасан зохицож, энэ хоёр хандлага цаашид улам бүр шүтэлцээ хамааралтай хөгжих буйзаа.

### Abstract

Comparative Politics special area within political science. Comparison is the methodological core of the scientific study of politics. It is emphasis on comparison itself, and on how and why political phenomena might be compared. No single substantive field in comparative politics. Distinctness of this political science's subfield is the combination of substance and method. Interest for comparative analysis recently reawakened in the aftermath of the Third wave of democratization. In article discussed theoretico-methodological development of comparative politics. Our analysis concerns the scope and range of comparison, the actual topics and questions in comparative political studies, also present trends.

### Ишлэл зүүлт

1. Almond G. 1990. A Discipline Divided. London: Sage. p.192
2. Ibid., p.215.
3. Skocpol, T. States and Social Revolution. Cambridge University Press.
4. Mair, P. 1996. Comparative Politics: An Overview. A New Handbook of Political Science. Oxford University Press. p.316.
5. Ibid., pp.317-318
6. Shively, W. 1996. Comparative Governance. McGraw-Hill. p.5.
7. Mair, P. Ibid., p.324
8. Ж.Лейн, С.Эрссон Сравнительная политология: От политической социологии к сравнительной социальной политике / Политические процессы в России в сравнительном измерении. СПб., 1997. с.142.
9. Ж.Лейн, С.Эрссон. Указ. Соч., с.138-139.
10. Ильин М.В. Сравнительная политология: Научная компаративистика в системе политического знания // Полис. 2001. № 4. с.173.
11. Доган М., Пеласси Д. Сравнительная политическая социология. М.: Социально-политический журнал, 1994. с.65-85